

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД
НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Ко мпьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг шуудангаар болон цахимаар тус тус Байнгын хороонд явуулна.



НЭГ.НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	Эцэг/эхийн нэр: Бадамдорж Ургийн овог: Тайж Нэр: Төгсцэнгэл Хүйс: Эрэгтэй Төрсөн он: 1978 Нас: 47 Төрсөн газар: Төв аймгийн Мөнгөнморьт сум Иргэний харьяалал: Монгол Улс Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг /Мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал Төрийн албаны зөвлөлийн гишүүн
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. “Тийм” Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. “Үгүй”
1.4	Төрийн албан хаагч Төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан /хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. <u>Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт:</u> -2024.09.17-оос эхлэн Дотоод хяналтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч -2020.09.10-2024.09.17 -Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны Зөвлөх -2019.03.18-2020.09.10 -Хууль, эрх зүйн хэлтсийн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны ажлын албаны Зөвлөх

	-2016.03.16-2019.03.18 -Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны Референт -2012.04.19-2016.03.16 -Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн Эрх зүйн экспертын албаны Референт -2010.04.26-2012.04.19 -Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн Шинжээч
1.5	Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ. /Төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн;/ 1.2008.08.26 -Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль: “Хуулийн магистр” 2.2000.06.07 -Цагдаагийн академи: “Эрх зүйч мэргэжлээр, бакалавр”
1.6	<u>Эрхэлсэн ажил:</u> Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ. <u>Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт:</u> -2024.09.17-оос эхлэн -Дотоод хяналтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч -2020.09.10-2024.09.17 -Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны Зөвлөх -2019.03.18-2020.09.10 -Хууль, эрх зүйн хэлтсийн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны ажлын албаны Зөвлөх -2016.03.16-2019.03.18 -Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны Референт -2012.04.19-2016.03.16 -Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн Эрх зүйн экспертын албаны Референт -2010.04.26-2012.04.19 -Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн Шинжээч <u>Бусад:</u> -2009.02.05-2010.04.26 -Монголын Өмгөөлөгчдийн Холбоонд Өмгөөлөгч -2004.03.01-2009.02.05 -“Хас секьюрити сервис” ХХК-д Хуулийн зөвлөх
1.7	Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал Сүүлийн нэг жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.

	“Үгүй”
1.8	Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/ /Ял шийтгүүлж байгаагүй/ “Үгүй”
1.9	Сахилгын шийтгэлийн талаар Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. “Үгүй”
1.10	Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Төрийн бус байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүрэг, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ. “Үгүй”
1.11	Нэр дэвшигч нь хэрэв байгаа бол доор дурдсан мэдээллийг бичнэ -Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ. - “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах сэдвийн танилцуулга” Улаанбаатар хот, 2017 он УИХТГ /хамтарсан/ - ““Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын асуултын лавлагаа, танилцуулга” Улаанбаатар хот, 2023 он УИХТГ /хамтарсан/ -Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ. Хуулийн төслийн эхийг барьж ажилласан хуулиуд: - Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга; - Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний тухай хууль; - Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга; - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга; - Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга; - Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулга.

	-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ. -сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө. <i>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</i>
--	---

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/. Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилогдвол хэрэгжүүлэх ажлын чиглэл, нэр дэвших үндэслэл Б.Төгсцэнгэл миний бие Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлага болон “Төрийн жинхэнэ албанд 15-аас дээш жил ажилласан туршлагатай, төрийн удирдлага, эрх зүй, эдийн засаг, боловсролын чиглэлээр мэргэшсэн дээд боловсролтой, ял шийтгэлгүй, 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна.” гэсэн шаардлагуудыг хангаж байгаа тул Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшихээр төрийн албан хаагчийн төлөөллийн сонгон шалгаруулалтад өрсөлдсөн. Миний хувьд 2000 онд Цагдаагийн академийг эрх зүйч мэргэжлээр бакалавр зэрэгтэй, 2008 онд МУИС-ын Хууль зүйн сургуулийг Хуулийн магистр зэрэгтэй тус тус төгссөн. 2004 онд ажлын гараагаа “Хас секьюрити сервис” ХХК-д хуулийн зөвлөхөөр эхлүүлж, 2009 оноос Монголын Өмгөөлөгчдийн холбоонд өмгөөлөгчөөр ажиллаж байгаад 2010 оноос Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт шинжээчээс, референт, зөвлөх, хэлтсийн даргаар шатлан дэвшиж 15 жил тасралтгүй ажиллаж байна. Энэ хугацаанд Монгол Улсын Их Хурал, түүний Байнгын болон дэд хороо, ажлын хэсгийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, энэ хүрээнд хууль санаачлагчаас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүд болон бусад тодорхой асуудлыг Улсын Их Хурлын Байнгын хороодын хуралдаан болон нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, зарчмын зөрүүтэй саналын томьёолол, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн. Мөн “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар зохион байгуулсан Анхдугаар зөвлөлдөх санал асуулга” болон “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулахад тус тус оролцож, Зөвлөлдөх зөвлөлийн ажлын албаны Нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэсэн. Би төрийн албанд ажиллах хугацаандаа ёс зүйтэй, хариуцлагатай байж, хуульд захирагдах зарчмыг тууштай мөрдөж ирсэн.
-----	--

Миний бие Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилогдвол төрийн албыг илүү мэргэшсэн, тогтвортой, иргэн төвтэй, хүний эрхийг дээдэлсэн, ил тод, нээлттэй, оновчтой бүтэц, зохион байгуулалттай, өндөр бүтээмжтэй болгоход анхаарч ажиллах болно. Тухайлбал:

Төрийн албан хаагчийн томилгоо болон шатлан дэвших асуудлыг мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлагад тулгуурлан шийдвэрлэх, төрийн албан хаагчийн хөгжлийг дэмжсэн, ил тод, нээлттэй тогтолцоог төлөвшүүлэх, төрийн албаны чадахуйн зарчимд суурилсан, мэргэжлийн ур чадвар, чадавхыг үнэлсэн сонгон шалгаруулалт, хүний нөөцийн бодлогыг уян хатан байдлаар хэрэгжүүлэх бодлогыг дэмжиж, санаачилгатай ажиллана.

Төрийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт, мониторинг, үнэлгээний арга зүйг илүү боловсронгуй болгох, зөвхөн тоон үзүүлэлтээр бус, иргэнд үзүүлж буй бодит үр нөлөөгөөр хэмжих тогтолцоог төлөвшүүлэх, хариуцлагын соёлыг хэвшүүлэх, бодлогын уялдаа холбоог хангах, түүнчлэн ажилтны гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог үр ашигтай нэвтрүүлэх, төрийн албан хаагчийн зөвхөн гүйцэтгэлийг бус, түүнчлэн бүтээмж, ур чадварыг үнэлдэг, бодит үр дүнд суурилсан үнэлгээний тогтолцоог төлөвшүүлэхэд анхаарч, бүтээлчээр ажиллах болно.

Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийн хүрээнд төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ болон процессын дахин инженерчлэлд тулгуурлан тэдгээрийн ажлын зохион байгуулалт, үйл явц, бүтэц, үйл ажиллагааг оновчтой, давхардалгүй, харилцан уялдаатай, үр ашигтай, иргэдэд илүү хүртээмжтэй байхаар сайжруулахад анхаарч ажиллана.

Төрийн албанд орох, албан тушаал дэвших, мэргэших, сургалтад хамрагдах бүхий л үйл явцыг ил тод, цахим шийдлийг илүү боловсронгуй болгох нь шударга, тэгш орчныг бүрдүүлнэ гэж үзэж байна. Ингэснээр төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт, гүйцэтгэлийн үнэлгээ зэрэгт цахим шийдлийг ашиглах замаар шийдвэр гаргах үйл явцын ил тод, үр нөлөөтэй, хүртээмжтэй байдлыг сайжруулна гэж үзэж байна.

Би хуульч хүний хувьд төрийн албыг илүү мэргэшсэн, тогтвортой, хүний эрхийг дээдэлсэн, иргэн төвтэй, ил тод, нээлттэй болгох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн давхардал, хийдлийг арилгах, хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэхэд чиг үүргийнхээ хүрээнд хувь нэмрээ оруулж ажиллахыг зорьж байна.